



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 4/66

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Аянчин Фоор Сийзонз Лодж ХХК-ийн “Аянчин Фоор Сийзонз Лодж” амралтын газрын 19/299, Цоглог Хангай ХХК-ын “Титэм” зочид буудлын 19/330, Эль Хаус ХХК-ийн “Эль Хаус” зочид буудлын 19/336, Хэрлэн Буян ХХК-ийн “Лойт Хаус” дэн буудлын 19/315, Аглаг-Эрдэнэ ХХК-ийн

1150500131

"Аглаг-Эрдэнэ" дэн буудлын 19/317, ТБА ХХК-ийн "Наран" дэн буудлын 19/346, МБММ ХХК-ийн "Уянга" дэн буудлын 19/323 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 08 сарын
28-ны өдрийн А/66 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Эль Хаус ХХК	2856352	Эль хаус	БГД-ийн, 17-р хороо, 4-р хороолол Амарсанаагийн гудамж 23-1
2	Эль Хаус ХХК	2856352	Эль хаус-2	БГД-ийн, 9-р хороо, 3-р хороолол Ард Аюушийн өргөн чөлөө 65
3	Цоглог Хангай ХХК	2542811	Титэм	СХД-ийн, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 105

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 08 сарын
28-ны өдрийн А/66 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284025 СБТ-8926 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 08 дугаар сарын 19-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хэрлэн Буян ХХК	2547163	Лойт Хаус	БГД-ийн, 11-р хороо, Хасбаатарын гудамж
2	Аглаг-Эрдэнэ ХХК	5175429	Аглаг Эрдэнэ	ЧД-ийн, 19-р хороо, Нуурын 19-404
3	ТБА ХХК	2708108	Наран	БЗД-ийн 22-р хороо, Өлгийн 11-152
4	МБММ ХХК	2600072	Уянга	БГД-ийн, 5-р хороо, 10-р хороолол, 11-2
5	Гаамаа Ээж ХХК	6329365	Эндо	БГД-ийн, 16-р хороо, Орхоны 4-р гудамж 19 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 08 сарын
28-ны өдрийн А/66 дугаар дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ-А-8936 1118203502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 08 дугаар сарын 19-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Грийн Глобус Френдс ХХК	6513166	Грийн Глобус Френдс	НД-ийн, 5-р хороо, Уу булан
2	Аянчин Фоор Сиизонз Лодж ХХК	2872595	Аянчин Фоор Сиизонз Лодж	НД-ийн, 6-р хороо, Эрээний Адаг

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР